



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 545

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хавдар судлалын үндэсний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 24,968,041.00 (хорин дөрвөн сая есөн зуун жаран найман мянга дөчин нэгэн) төгрөгийн балансын үнэ, 14,402,861.78 (арван дөрвөн сая дөрвөн зуун хоёр мянга найман зуун жаран нэгэн төгрөг далан найман мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Говь-Алтай аймаг дахь салбар Анагаах ухааны сургуульд балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Хавдар судлалын үндэсний төвийн Ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Эрдэнэхүү, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Захирал Н.Хүрэлбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Автомашинны улсын дугаарыг шилжүүлэн хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-г үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 4 дугаар сарын 22-ны өдрийн
15 дугаар тогтоолын хавсралт

**ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛИЙН ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ САЛБАР АНАГААХ УХААНЫ СУРГУУЛЬД БАЛАНСААС
БАЛАНСАНД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**



Д/д	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, арлын дугаар	Үйлдвэрлэсэн /ашиглалтад/ орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ /төгрөг/	Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Үлдэх өртөг /төгрөг/
1	TOYOTA Hiace, арлын дугаар TRH22600052998, улсын дугаар 86-83УБО	2008/2019	136813	24,968,041.00	14,402,861.78	10,565,179.22
НИЙТ ДҮН				24,968,041.00	14,402,861.78	10,565,179.22
				(хорин дөрвөн сая есөн зуун жаран найман мянга дөчин нэгэн)	(арван дөрвөн сая дөрвөн зуун хоёр мянга найман зуун жаран нэгэн төгрөг далан найман мөнгө)	(арван сая таван зуун жаран таван мянга нэг зуун далан есөн төгрөг хорин хоёр мөнгө)